



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 03/39

Баян-Өндөр сум

Тогтоолын хавсралтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07/09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны үйл ажиллагааны журам”-ын Долоод “Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өөрчлөх, татан буулгах” гэснийг “Хороо, бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өөрчлөх, татан буулгах” гэж, 7.1 дэх заалтад “Хурлын дарга, Хурлын Зөвлөлөөс хорооны үйл ажиллагааны зардлын төсвийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэх ба бусад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ. Хорооны санхүүжилтийн тайланг хууль, журмын дагуу гаргах үүргийг хорооны дарга хүлээнэ” гэснийг “Хурлын дарга, Хурлын Зөвлөл, Бүлэг, Хорооны үйл ажиллагааны зардлын төсвийг жил бүрийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх ба бусад шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ” гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ